



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/405

Мөрөн сум

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.7, 43 дугаар зүйлийн 43.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулахыг хавсралтаар баталсугай.

2.Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж баталгаажуулсны үндсэн дээр 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор энэ захирамжийн 1-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.

3.Захирамжийн 1-2-т заасан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх болон хөрөнгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулах, санхүүжүүлэхэд шалгуур үзүүлэлт гаргаж, нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газар (Г.Гандэлгэр)-т даалгасугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР